

ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН – 40 ЖИЛ

1. Хүрээлэн үүсэн байгуулагдсан түүх

Төв Азийн соёл иргэншлийн эртний бие даасан голомтын нэг Монгол орон Дорно-Өрнийн улс түмний түүхийн хуудаснаа баттай байр эзэлдэгийн хувьд, бусад улс түмний соёл, хэл, эрт өдгөөгийн түүх, улс төр, эдийн засгийн бодлогыг шинжлэн судлах, хэрэгцээ шаардлага тэдгээр улс оронтой харилцах явцад урган гарч байдгийн улмаас манай оронд дорнодахины судлал хэмээх шинжлэх ухааны салбар үүсэн хөгжиж, улмаар олон улс судлал болон өргөжин тэлэв.

Монголын түүх судлалын баялаг уламжлал, монгол төрийн гадаад харилцааны туршлага сургамжинд тулгуурлан, Монгол Улсад олон улс судлалын биеэ даасан эрдэм шинжилгээний байгууллага үүсэн хөгжсөн явдал манай орны шинжлэх ухааны хөгжлийн түвшинг илтгэн харуулах томоохон үйл явдал мөн юм.

1961 онд ШУА үүсэн байгуулагдаж, Монголын шинжлэх ухаан хөгжлийнхээ цоо шинэ үе шатанд дэвшин орлоо. Шинжлэх Ухааны Академитай байгаа бол тэр улс тусгаар тогтносон улс мөн гэх бөгөөд академич Б.Ширэндэвийн үүсгэн байгуулж гал голомтыг нь асаасан Монголын ШУА-д байгаль, нийгмийн шинжлэх ухааны шинэ шинэ салбар үүсэн бий боллоо. Шинжлэх ухааны ийм шинэ салбарын нэг бол Монгол Улсын гадаад харилцаа, гадаад орон судлах Олон Улс Судлалын ухаан бөгөөд үүний эхлэл нь ШУА-ийн анхны ерөнхийлөгч академич Б.Ширэндэвийн санаачлага, дэмжлэг, шууд оролцоотойгоор МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1968 оны 1-р сарын 4-ний өдрийн 03 тоот тогтоолоор ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын дэргэд байгуулсан, Ази-Африк судлалын хэлтэс юм.

Тухайн үеийн нийгмийн хөгжлийн шаардлага, олон улсын байдал, улс хоорондын харилцааны төвөгтэй байдлаас шалтгаалан ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын тогтоолоор 1968 оны 5-р сарын 4-нд Ази-Африкийн судлалын хэлтсийг Дорнодахины судлалын хэлтэс болгон өөрчлөн зохион байгуулжээ. Уг хэлтэст ажиллах боловсон хүчинг сонгон авах, тэдний судалгааны ажлыг удирдан зохион байгуулах талаар ШУА-ийн удирдлага чухалчлан анхаарч, Намын дээд сургуулийн Монголын түүхийн багш, хятад судлаач, дэд эрдэмтэн Л.Жамсранг Ази судлалын тасгийн дарга бөгөөд Дорнодахины судлалын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгчээр, Африк, Латин Америкийн тасгийн даргаар улс төр -дипломатын арвин туршлагатай түүхийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, дэд эрдэмтэн

Н.Дангаасүрэн нарыг томилжээ. Ингээд хамт ажиллах багийн ажилтнаар хятад, япон хэлний мэргэжилтэн, түүхч Ц.Хандсүрэн, ГЯЯ-нд ажиллаж байсан франц хэлний мэргэжилтэн Б.Саялхам, олон улсын харилцааны мэргэжилтэн, хинди судлаач Д.Пүрэв, МОНЦАМЭ агентлагийн англи хэлний орчуулагч Итгэл нарыг сонгон авч томилон ажиллуулснаар эрдмийн шинэ хамт олон бүрэлдэж Улсын түүхийн музей, одоогийн байгалийн музейн ганц өрөөнд судалгааны ажлын гараагаа эхэлсэн түүхтэй.

Дорнодахины судлалын хэлтсийн ажилтнууд бүгд 2-3 гадаад хэлний зохих мэдлэгтэй, гадаад харилцаа, түүхийн салбарт ажиллаж байсан тул эрдэм шинжилгээний ажилдаа хурдан дадлагажиж, онол-арга зүйн судалгааны түвшингээ дээшлүүлэх талаар ихэд чармайн ажиллаж байжээ.

Хэлтэс байгуулагдсан эхний саруудад академич Б.Ширэндэв, Ш.Нацагдорж, Ш.Бира, доктор М.Санждорж, Ш.Сандаг нарын Монголын урдаа барьдаг том эрдэмтэдээр цуврал лекц уншуулж судалгааны ажлын чиг баримжааг тодотгон тогтоож, судалгааны арга барил эзэмшүүлэх, эрдмийн хамт олон жинхэнээр төлөвшин бүрэлдэхэд тал бүрийн дэмжлэг туслалцаа үзүүлж байв. МАХН-ын Төв Хорооны Гадаад харилцааны хэлтэс, Үзэл суртлын хэлтсээс тухайлан тус хэлтсийн судалгааны ажлыг ялангуяа дорнодахин судлал, тэр дундаа хятад судлалд голчлон чиглүүлэхэд онцлон анхаарч, судалгааны ажлыг нь хэвлэл мэдээллийн байгууллагуудтай холбож өгөх, практикийн болон ажил төрлийн холбоотой байж болох байгууллагуудтай нягт уялдуулах болон материаллаг баазыг нь бэхжүүлэх, судалгааны материал, ном хэвлэлээр хангах зэрэг ажлыг зохицуулж байв.

Тухайн үед хэлтсийн судалгааны өөр нэг гол чиглэл нь манай Монгол орны капиталист биш хөгжлийн 50 шахам жилийн түүхэн замналыг, ерөөс капиталист биш хөгжлийн онол, практикийн асуудал, тухайлан Ази, Африк, Латин Америкийн шинэ залуу улс орнуудын хөгжлийн төлөв байдлыг марксист-ленинист үзэл суртал, байр сууринаас судлах байлаа.

1968 оны 9-р сард манай улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны 1-р нарийн бичгийн даргаар ажиллаж байсан, Бээжингийн их сургууль төгссөн түүхч, хятад судлаач эрдэмтэн Ч.Далай тус хэлтсийн анхны даргаар томилогдон ирж ажиллажээ. Тэр үеийг Ч.Далай багш дурсан ярихдаа: Б.Ширэндэв ерөнхийлөгч намайг өрөөндөө дуудан “Монголын шинжлэх ухаан улам улам өргөжин хөгжиж байна. Одоо бид олон улсын, түүний дотор Азийгаа судлах хэрэгтэй. Ер нь Ази тив бол унтаж байгаа их хүч юм. Нэг өдөр сэрвэл тэрээр дэлхийд тэргүүлэгч

үүрэгтэй болно. Чи энэ ажлыг сайн хийх хэрэгтэй. Хятад судлалыг бүр ч сайн хий. Бие даасан том хүрээлэн болтол ажиллах ёстой гэж билээ. Б.Ширэндэв гуайн тэр үг нь үнэн л байсан. Ийм алсын хараатай үг хэлдэг хүн байлаа” гэж дурсан ярьдаг билээ.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн 1968 оны 12-р сарын 17-ны өдрийн хуралдаанаар Дорнодахины судлалын хэлтэс болон өргөжсөнтэй холбогдуулан хэлтсийн Эрдмийн Зөвлөлийг эмхлэн байгуулжээ. Дорнодахины судлалын хэлтсийн дарга, эрдмийн зөвлөлийн даргаар Ч.Далай, эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Л.Жамсран нарыг баталжээ. Эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнд академич Ц.Дамдинсүрэн, Ш.Бира, доктор, профессор Чой.Лувсанжав, Э.Чимидсэрэн, Ч.Жүгдэр нарын зэрэг нэртэй эрдэмтэн 11 хүн оржээ.

Ийнхүү ганцхан жилийн дотор Монгол Улсад дорнодахин судлалын бие даасан эрдэм шинжилгээний байгууллага өсөн бэхжиж, эрдмийн хамт олон бүрэлдэж, цааш цаашдын эрдэм судлалын номын буян хурах зам тавигдсан байна.

Дорнодахины судлалын хэлтэс аажимдаа номын сан, тусгай фонд, гадаадын ном хэвлэл, сонин сэтгүүлийн хөмрөгтэй болж, ЗХУ, Хятад, Гонконг, Тайвань зэрэг орны тогтмол хэвлэл, ном сэтгүүл захиалахад дээд байгуулагаас анхааран дэмжиж жил бүр тухайн үеийн ханшаар 1200 долларын гуравлагч орны хэвлэл захиалж авах эрхтэй болжээ. Мөн ажиллах орон байраар хангах, шинэ залуу ажилтнаар бэхжүүлэх, материаллаг баазыг өргөтгөх ажлыг шат дараатай хийж байв.

Боловсон хүчний хувьд гэхэд л тухайлбал, дипломат алба хашиж байсан араб хэлний мэргэжилтэн, зохиолч Д.Маам, англи хэлний мэргэжилтэн, түүхч Э.Пунцаг, Олон улсын харилцааны мэргэжилтэн, испани хэлтэй Б.Батболд, Л.Хайсандай, хятад хэлний мэргэжилтэн, түүх судлаач А.Дамдинсүрэн, франц хэлтэй Ч.Сувд, З.Эрдэнэчимэг нарын гадаад хэлний зэгсэн сайн мэдлэгтэй, гадаад орон судлалын арга туршлагатай ажилтнаар Дорнодахин судлалын хэлтсийн ам бүлийг нэмсэн юм.

Тийнхүү шинэ тулгар байгуулагдсан Дорнодахины судлалын хэлтсийг өргөжүүлэн бэхжүүлэх, ялангуяа олон улсын харилцааны мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн боловсон хүчнээр хангах, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулахад тэр үеийн ЗХУ-ын эрдэмтэд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлсэн байна. Тухайлбал, 1969 оны 7-р сард ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн захирал, нэрт хятад судлаач М.И.Сладковский, академич С.Л.Тихвинский нар манай оронд уригдан ирж, тус оронд дорнодахины судлалыг хөгжүүлэх, шинжлэх ухааны үндэслэл, эрдэм

шинжилгээний ажлын сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулахад гүн туслалцаа үзүүлсэн юм. Энэ нь тус хэлтсийг хүрээлэн болгон өргөжүүлэх, хоёр орны тухайн салбарын хамтын ажиллагааны үндэс суурийг тавьж, хамтран ажиллах, монголын судлаачдыг өсөн дэвжихэд чухал ач холбогдолтой үйл явдал болжээ.

Тус хэлтэс нь манай оронд, Шинжлэх Ухаан Академийн системд Ази, Африк судлалаар анхлан “гал голомтоо” асааж улмаар дорнодахин судлалыг шинжлэх ухааны хувьд нь хөгжүүлэх, ялангуяа ХХ зууны 60, 70-иад оны үеэс олон улсын тавцанд гарч ирсэн маоизмын мөн чанарыг шинжлэн судлах, манай өмнөд хөрш БНХАУ-ын тухайн үеийн эрх баригчдаас БНМАУ-ын талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл, эрдэм шинжилгээний ул суурьтай судалгаа хийх, практик ач холбогдолтой ном зохиол, өгүүлэл зэргийг туурвихад гол анхаарлаа хандуулж байв. Үүнд: “Гуравдагч ертөнцийн орнуудын эдийн засгийн тусгаар тогтнолын зарим асуудал”, “Монгол-Хятадын харилцаа /1900-1949/”, “БНМАУ-БНХАУ-ын харилцаа /1949-1975/”, “БНМАУ-ын гадаад бодлого /1921-1976/”, “Маогийн бодлогод хэлмэгдэж буй Төвд орон”, “Өвөр Монголын товч түүх”, “Маоизм маогийнхан” зэрэг нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл зэрэг хэд хэдэн бүтээл хэвлэн нийтэлснийг дурьдаж болох юм.

Олон улсын тавцанд эсрэг тэсрэг хоёр үзэл суртлын тэмцэл эрс хурцдаж байсан 70-аад оны дунд үеийн улс хоорондын харилцаа ч тэр үеийн эрх баригч нам, төрийн бодлогоос ангид байгаагүй билээ. Тухайн цаг үеийн байдалтай уялдуулан, тэр үеийн социалист улсуудын Хятад судлалын төвүүдийн эрдэм шинжилгээний ажил өрнөж, хамтын ажиллагаа улам бүр өргөжиж буйг харгалзан 1976 оны 7-р сарын 2-нд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоолоор ШУА-ийн Дорнодахин судлалын хэлтсийг хүрээлэн болгон өргөтгөн байгуулсан юм.

Энэ тогтоолын үндсэн дээр БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 12-р сарын 3-ны өдрийн 402 тоот тогтоолоор Дорнодахин судлалын хүрээлэнг хятад судлалын, хөгжиж байгаа ба хөрөнгөтөн орон судлалын, хэвлэл-мэдээллийн гэсэн 3 тасагтай, 30 хүнтэй зохион байгуулснаар хүрээлэнгийн түүхийн шинэ үе шат эхлэв.

Хүрээлэнгийн анхны захирлаар ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Ш.Бира, орлогч захирлаар доктор Н.Ишжамц, эрдэмтэн нарийн бичгийн даргаар дэд эрдэмтэн Ч.Далай, хятад судлалын тасгийн даргаар дэд эрдэмтэн Л.Жамсран, хөрөнгөтөн ба хөгжиж буй орон судлалын тасгийн даргаар дэд эрдэмтэн Н.Дангаасүрэн, хэвлэл мэдээллийн тасгийн даргаар Э.Пунцаг нар тус тус томилогдон ажиллажээ.

Дорнодахин судлалын судалгааны цар хүрээ өргөжин, боловсон хүчнээр бэхжиж, ШУА-ийн бие даасан эрдэм шинжилгээний хүрээлэн болсоноор Монгол Улсын хэмжээнд дорнодахины болон олон улс судлалын талаар хийх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхэлсэн шинжлэх ухааны үндсэн байгууллага, гол төв нь болсон юм.

Энэ үеэс хүрээлэнгийн судалгааны цар хүрээ өргөжиж шинэ боловсон хүчнээр эгнээгээ тэлэв. 1970-аад оны сүүл үеэс М.Зэнээ, М.Хурметхан, Н.Алтанцэцэг, Д.Баясгалан, Л.Бэгзжав, Н.Ариунгуа, Ж.Баясах, Н.Төмөр, Ц.Баатар, Ц.Батбаяр, Б.Сэржав, Ч.Батцэцэг, Р.Отгонбаатар, Н.Баярбаатар, О.Оюунгэрэл зэрэг гадаад, дотоодод дорнодахины судлалаар их, дээд сургууль төгссөн залуу судлаачдын шинэ үеийнхэн дорнодахины хүрээлэнгээс ажил амьдралын гараагаа эхэлж байсан бол өдгөө тэдний ихэнх нь бүтээл туурвил ихтэй нэртэй эрдэмтэн, судлаачид болсон байна.

Хүрээлэнгийн үндсэн зорилт нь дорнодахины судлал, гадаад орон судлалын асуудлаар эрдэм шинжилгээний тулгуур судалгаа хийх, мөн орчин үеийн олон улсын харилцааны тулгамдсан асуудал, онол, практикийн цаг үеийн гол чухал асуудлыг түүх, эдийн засаг, олон улсын эрх зүйн үүднээс судлан боловсруулж, энэ талаар дэлхийн бусад орны шинжлэх ухааны ололт, арга туршлагаас эзэмшин, судалгаа шинжилгээгээ гүнзгийрүүлэхэд чиглэж байв.

Хүрээлэнгийн судалгааны гол цөм нь хятад судлал байж, хятадын дотоод, гадаад бодлого, хятад дахь үндэстний асуудал байлаа. Энэ чиглэлээр ЗХУ-ын Алс Дорнодын институт, Дорнодахины хүрээлэн болон Чехсловак, Герман, Польш, Болгар зэрэг орны зохих байгууллагатай судалгааны ажлаа уялдуулж, ажилтнуудаа тэгш солилцооны журмаар явуулж, мэргэжил дээшлүүлэх, улмаар БНХАУ-д хэлний дадлага хийлгэдэг болсон юм.

1980-аад оны сүүлч үеэс дэлхий дахинаа олон арван жил ноёрхсон “хүйтэн дайн”-ы үе дуусч шинэчлэл, өөрчлөн байгуулалт гарч, улс төрийн шинэ сэтгэлгээ төлөвших болсноор улс түмнүүд олон улсын шинэ орчин, шинэ харилцаанд шилжих үндэс суурь тавигдсан билээ. Олон улсын энэ шинэ нөхцөл байдал манай улсын гадаад бодлогод төдийгүй дотоод байдалд ч эргэлтийн шинжтэй нөлөөлсөнөөр Дорнодахины судлалын хүрээлэнгийн шинжилгээ судалгааны ажлын хүрээ тэлж, уламжлалт хятад судлал, үндэстний асуудал, хөгжиж буй орон судлалын зэрэгцээ Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, Зүүн Хойт Азийн эдийн засгийн интеграци, БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлого, Монгол Улсын гадаад харилцааны шинэ хандлага, сайн хөршийн найрсаг харилцаа, “Гуравдагч түнш” хийгээд

Япон, Азийн “бар” орнуудын хөгжлийн туршлага гэх мэт шинэ шинэ судалгааны сэдвээр өргөжсөн билээ.

2. Дорнодахины судлалын хүрээлэнгээс Олон улс судлалын хүрээлэн

1990-ээд оны эхээр Монгол Улс ардчилал, зах зээлийн нийгэмд шилжиж, Монгол Улсын гадаад орчин эрс өөрчлөгдсөний улмаас хүрээлэнгийн судалгааны чиглэлийг бий болсон шинэ нөхцөл байдалтай уялдуулан улам боловсронгуй болгох, хянан үзэх шаардлага гарсан юм. Иймд хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлийн саналаар тус хүрээлэнг Дорнодахин, Олон улс судлалын хүрээлэн хэмээн шинэчлэн нэрлэх болов.

Хүрээлэнгийн нэрийг шинэчлэн өргөтгөхтэй уялдуулан судалгааны объектыг шинэчлэн тогтоож, 1990 он хүртэл эрдэм шинжилгээний ажлыг секторын системээр явуулж байсныг өөрчлөн төслийн хүрээнд сэдвээр гүйцэтгэж эхлэв. Өмнө нь судалгааны сэдэв түүх, улс төр, үзэл суртал, сөрөг сурталчилгаа голлож байсныг өөрчлөн олон улсын харилцаа, гадаад орон, бүс нутгийн судлал, эдийн засгийн судалгаа болголоо. Монголын гадаад бодлого, Орос дахь үндэстний асуудал, Азийн орнуудын хөгжлийн туршлага, Монголын гадаад харилцааны түүх, Олон улсын харилцааны шинэ хандлага зэрэг сэдвээр олон шинэ санаа, шинэлэг дүгнэлтийг дэвшүүлэн тавих болов.

Хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын тоо нэмэгдэн, боловсрол өндөр боловсон хүчнээр бэхжиж, судалгааны хүрээ өргөжихийг дагалдаад Дорнодахин, олон улс судлалын төв, Зүүн Хойт Ази судлалын төв гэсэн судалгааны бие даасан хоёр байгууллага болж өрх тусгаарлав. Энэ нь улс орнуудын харилцан хамаарал гүнзгийрч, хөгжлийн бүсчилсэн хандлага хүчтэй болж, тухайлбал Зүүн Хойт Азийн орнуудтай улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан техник, экологи, хүмүүнлэгийн салбарт харилцан үр ашигтай хамтран ажиллах Монгол Улсын бодит хэрэгцээ шаардлагад үндэслэсэн юм. Дорнодахин, олон улс судлалын болон Зүүн Хойт Ази судлалын төвүүд нь 1991-1999 онуудад тус тусдаа үйл ажиллагаагаа явуулж, удирдлага, зохион байгуулалт, санхүү-аж ахуйн хувьд бие даан ажиллаж байсан хэдий ч судалгааны ерөнхий чиглэл, зорилго, боловсон хүчний хувьд бие биеэ нөхсөн байдалтай ажиллаж ирсэн юм.

Дорнодахин, олон улс судлалын төвийн захирлаар доктор Ц.Батбаяр, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Х.Дашдондов, Зүүн Хойт Ази судлалын төвийн захирлаар академич Ч.Далай, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Б.Сэржав нар ажиллаж байсан ба тэдгээрт академич Н.Ишжамц, Б.Лхамсүрэн, Б.Балдоо, доктор Н.Дангаасүрэн,

Л.Жамсран, Г.Сүхбаатар, С.Дамдинсүрэн нарын зэрэг нэртэй олон эрдэмтэд ажиллаж байв.

Манай улсын хувьд хамгийн ирээдүйтэй, үр ашигтай Зүүн Хойт Азийн бүс нутаг, тухайлан Орос, Хятад, Япон, Солонгос болон АНУ зэрэг улс орныг тухайн орнуудын эрдэмтэдтэй хамтрах буюу дангаар судлах явдал энэ үед зөвхөн эрдэм шинжилгээний төдийгүй улс төр, эдийн засаг, практикийн үлэмж чухал ач холбогдолтой байв. Энэ зорилгод тус хоёр төвийн үүрэг зорилго, үйл ажиллагаа бүхэлдээ чиглэж ирсэн болно. Тухайлбал, Дорнодахин, олон улс судлалын төвөөс эрхлэн Н.Ариунгуа “ХҮ-ХҮИ зууны Монгол Хятадын харилцаа” УБ. 1996, Л.Жамсран “Независимость Монголии и Китайская Республика” УБ. 1996, Ц.Батбаяр “Монгол ба Япон: XX зууны эхэн хагаст” УБ. 1998, “Россия и Монголия: новый взгляд на историю взаимоотношений в XX веке” М. 2001, Н.Ишжамц “БНХАУ-ын түүхийн товч тойм /нэн эртнээс 1999 он/” УБ. 1999, “1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс их гүрнүүдийн харилцаа” УБ. 1995, “Монголын Эзэнт гүрний гадаад харилцаа” УБ. 1995, “Хятад дахь монголчууд” УБ. 1996, “Өнөөгийн Хятад орон” УБ. 1996, “Өвөр Монголын өөртөө засах орон” УБ. 1998, “Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн засаглал” УБ. 2001 /монгол, англи хэлээр/ зэрэг хамтын бүтээл хэвлүүлэн олны хүртээл болгожээ. Зүүн Хойт Ази судлалын төвийн тухайд гэвэл “Зүүн Хойт Азийн хамтын ажиллагаа ба Монгол Улс”, “Монголын түүхийн зарим асуудал ба Монгол-Хятадын түүхэн харилцаа” зэрэг төслийг хэрэгжүүлж, Ч.Далай, “Их Монгол улс”, “Хамаг Монгол улс”, “Монголын түүх” гэсэн нэгэн сэдэвт 3 боть ном, Г.Сүхбаатар “Монгол-Нирун улс /330-555/” гэсэн монголын түүхийн содон шинэ бүтээлээ чухам энэ төвд ажиллах хугацаандаа туурвисан билээ. Үүнээс гадна тус төвөөс “Зүүн Хойт Ази: Эдийн засгийн хамтын ажиллагаа” /хамтын бүтээл/ УБ. 1995, Л.Хайсандай, С.Дамдинсүрэн, Б.Балдоо Хятад, Оросын харилцаан дахь Монгол Улс”, “Монголын тусгаар тогтнол ба Орос Хятадын хүчин зүйл” УБ. 1999, “Монгол улс ба Зүүн Хойт Ази” /хамтын бүтээл/, УБ. 2002, С.Дамдинсүрэн “Монголын тусгаар тогтнол: Эрин зууны баталгаажилт” УБ. 2001, Н.Дангаасүрэн “Улс тогтнох хүчин зүйл” УБ. 2001, Б.Балдоо “Монголын гадаад харилцаа: XX зууны эхэн ба төгсгөл” УБ. 2003, Л.Бэгзжав “Монгол-Хятадын харилцаа/1949-1999/ УБ. 1999, Монгол-Хятадын эрдэмтдийн хамтын бүтээл болох “XXI зууны эхэн дэх Монгол-Хятадын нийгэм эдийн засгийн харилцаа” УБ. 2000 гэх мэт олон ном зохиол туурвин бичиж, “Зүүн Хойт Ази судлал” гэдэг сэтгүүлийг тогтмол гаргаж байв.

Тухайн үеийн засаг төрийн бодлого, бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөс болж, 1997 оны 2-р сард Дорнодахин, олон улс судлалын төвийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх Олон улс судлалын төв болгон өөрчлөн байгуулсан юм. Тус төвийн захирлаар 1997-1999 он хүртэл доктор Ц.Батбаяр, 1999-2000 он хүртэл доктор /Ph.D/ Н.Алтанцэцэг, доктор /Ph.D/ С.Дашцэвэл нар ажиллаж байв.

Энэхүү бүтэц, зохион байгуулалт нь манай орны Дорнодахин, олон улс судлалын шинжлэх ухааны хувьд бие даан хөгжихөд тустай зүйл болоогүйг амьдрал аяндаа харуулсан юм.

Цагийн ороо бусгаа байдал, түүхэн цаг үеийн шаардлага, судалгааны хүчийг нэгтгэн нягтруулах зорилгын үүднээс Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 9-р сарын 2-ны өдрийн “Шинжлэх ухааны зарим байгууллагын бүтцийн өөрчлөлтийн тухай” 138 тоот тогтоолын дагуу Түүхийн хүрээлэнгийн дэргэдэх Дорнодахин, олон улс судлалын төв, Зүүн Хойт Ази судлалын төв, мөн бусад зарим төвүүдийг нэгдмэл зохион байгуулалтанд оруулан нэгтгэж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулж, Олон улс судлалын хүрээлэн болгон өөрчилж эмхлэн байгуулав.

Олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар доктор, профессор Л.Хайсандай, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор /Ph.D/ Д.Шүрхүү нар томилогдож, өнөөг хүртэл үр бүтээлтэй ажиллаж байна.

ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2003 оны 3-р сарын 13-ны өдрийн 04 тоот тогтоолоор ОУСХ нь Орос судлалын салбар, Хятад судлалын салбар, Америк-Европ судлалын сектор, Япон судлалын сектор, Солонгос Зүүн Ази судлалын сектор гэсэн бүтэцтэй үйл ажиллагаагаа явуулсан байна. Сүүлийн жилүүдэд олон улсын харилцааны онол, арга зүй өөрчлөгдөж, дэлхий дахинаа глобалчлал, терроризм, салан тусгаарлах үзэл, аюулгүй байдал, дайн-энхийн асуудал зэргийг үнэлэх үнэлэмж, дүгнэлт эрс өөрчлөгдөж, үүнтэй уялдан хүрээлэнгийн судалгааны цар хүрээ ч өргөжин тэлэв. Мөн тус хүрээлэнд боловсрол мэдлэгтэй шинэ залуу олон боловсон хүчинг урьж ажиллуулах болов. Энэ ч үүднээс, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн үлгэрчилсэн дүрмийн заалтыг үндэслэн, ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2008 оны 1-р сарын 15-ны 03/08 тоот тогтоолын дагуу хүрээлэнд бүтцийн өөрчлөлт дахин хийж, Орос судлал, Хятад судлал, Япон судлал, Европ судлал, Солонгос –Зүүн Ази судлал, АНУ-Канад судлал, Төв Ази судлалын гэсэн 7 сектортой болсон байна. Эдгээр секторыг шинжлэх ухааны доктор О.Батсайхан, доктор /Ph.D/ Л.Бэгзжав, доктор /Ph.D/ Б.Сэржав, магистр Д.Золбоо, магистр Б.Цэнгэлхам, шинжлэх ухааны доктор Ц.Баатар, доктор /Ph.D/ К.Дэмбэрэл нар удирдан ажиллаж байна. Өнөөгийн байдлаар тус хүрээлэн гэрээгээр ажиллаж буй эрдэмтдийг

оролцуулан эрдэм шинжилгээний 40 ажилтантайгаас академич 1, шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор 7, доктор /Ph.D/ 12, магистр 11 байна. Өөрөөр хэлбэл, хүрээлэнгийн нийт ажилтны 82,5% нь эрдмийн зэрэг цолтой байгаа нь ШУА-ийн бусад хүрээлэнгийн дунд байхгүй үзүүлэлт юм. Энэ бол бидний бахархал боловч бид улам их хариуцлага үүргээ ухамсарлаж, хүчээ дайчилж улам ихийг хийж бүтээхийг улс эх орон, шинжлэх ухааны байгууллага хүсэн хүлээж байгааг ойлгож байгаа билээ.

40 жилийн түүхэнд тус хүрээлэнд олон алдар гавьяат, нэр хүндэт буурал эрдэмтэдээс эхлээд шинэ залуу олон хүн ажиллаж, ажил амьдралын замаа шинжлэх ухаанд зориулан үр бүтээлтэй хөдөлмөрлөж ирлээ. Тус хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, захиргаа техник, үйлчилгээ, санхүүгийн ажилтан гээд 150 гаруй хүн нэгэн хамт олон болж 40 оныг үджээ.

Хувь тавилангийн эрхээр ертөнцийн мөнх бусыг үзүүлэх хийгээд сургууль соёлын мөр хөөн одох, өөр ажил албанд шилжих ажиллах хөдөлгөөн ямагт гарч байсан ч дорно дахин, олон улс судлалын хүрээлэнгийн хамт олон. Монголын нийгмийн шинжлэх ухаанд нөлөөтэй, нэр төртэй байр суурь эзэлж монголын олон улс судлалын цөм хүчин байсаар байна. Хүрээлэнгээрээ овоглосон шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн академич Н.Ишжамц, Ч.Далай, Т.Намжим, шинжлэх ухааны доктор Л.Жамсран (Sc.D), Л.Хайсандай (Sc.D) нарын 5 гавъяат төрөн гарсан юм.

Тус хүрээлэнд Ш.Сандаг, Н.Дангаасүрэн, Ч.Далай, Л.Жамсран, М.Зэнээ, Ц.Батбаяр, Л.Хайсандай, М.Хурметхан, О.Батсайхан, Р.Жамц, Ц.Баатар нарын 11 шинжлэх ухааны доктор, Д.Маам, А.Дамдинсүрэн, Б.Батболд, Н.Алтанцэцэг, Ж.Баясах, Л.Хайсандай, Д.Баясгалан, С.Дашцэвэл, Р.Отгон, М.Зэнээ, М.Хурметхан, А.Буянтөгс, Ц.Баатар, Н.Ариунгуа, Л.Бэгзжав, Б.Сэржав, Д.Шүрхүү, К.Дэмбэрэл, Ч.Батцэцэг, Н.Төмөр, А.Нямдолжин, Д.Зоригт нарын 22 доктор (Ph.D) эрдмийн зэрэг хамгаалсан байна. Гадаад, дотоодын хүндтэй эрдэмтэд М.И.Гольман (ОХУ), Пима Гялбу (Япон), С.К.Рошин (ОХУ), Н.Багабанди (Монгол Улс), Г.Төмөрчулуун (Монгол Улс), Наран (БНХАУ) нарын 6 эрдэмтэн шинжлэх ухааны докторын зэргийг манай хүрээлэнгийн эрдмийн зөвлөл дээр хамгаалсан юм.

Үүнээс гадна тус хүрээлэнгээс:

Боловсролын доктор (Ph.D)

С.Отгонбаатар (Монгол улс), Д.Тэрбиш (Монгол улс), Рю Ён Чхөл (БНСУ), Ду Шивэй (БНХАУ), Шин Сан Кюнь (БНСУ), Б.Сэчинбат (БНХАУ), Ф.Билдаев (ОХУ)

Судалгааны профессор (Research Professor):

Ц.Хандсүрэн, Ж.Энхсайхан, С.Дамдинсүрэн, Ц.Батбаяр, М.Хурметхан, Р.Жамц, Ц.Баатар, Д.Билигт, Н.Төмөрхүлэг, Н.Дугарсүрэн, Д.Гарам-Очир, Ц.Баатар

Хүндэт докторууд:

Роберт Скалапино (АНУ), Р.Рыбаков (ОХУ), Б.Мацуда (Япон), Хуан Жякуй (БНХАУ), М.Тереза (АНУ), Ю.Ванин (ОХУ), М.Ханада (Япон), Удо Б.Баркмани (ХБНГУ), О.Дерковский (ОХУ), Ж.Бейкер (АНУ), П.Мета (НҮБ), Л.Түдэв (Монгол Улс), Б.Жаргалсайхан (Монгол Улс), Ш.Бира (Монгол Улс), Ц.Гомбосүрэн (Монгол Улс), С.Дамбадаржаа (Монгол Улс), Л.Моломжамц (Монгол Улс) нарын гадаад дотоодын нэр хүндтэй 7 эрдэмтэн, 12 судалгааны профессор, 17 хүндэт доктор төрөн гарсан нь хүрээлэнгийн нэр төрийн баталгаа болж байдаг юм.

Хүрээлэнд ажиллаж байсан академич Ш.Бира, Б.Лхамсүрэн, Б.Балдоо, доктор С.Ишдорж, Б.Гунгаадаш, Г.Сүхбаатар, С.Дамдинсүрэн, Х.Дашдондов, Д.Маам, Х.Хулан, Б.Батхишиг нарын үе үеийн эрдэмтэн докторууд бидний бас нэг бахархал юм.

Түүнчлэн хүрээлэнгийн ажлын хүндийг үүрэлцэж, эрдэм шинжилгээ, техникийн ажилд идэвхитэй, үр бүтээлтэй ажиллаж байсан, одоо ч зарим нь ажиллаж буй Ч.Бямбаа, эрдэм шинжилгээний ажилтан З.Эрдэнэчимэг, Ч.Сувд, н.Түмэнжаргал, н.Лувсанчүлтэм, Я.Дүнгэр-Яйчил, Ч.Лхамсүрэн, С.Баасанжав, Д.Цэдэв, О.Оюунгэрэл, Н.Бадамханд, Л.Лхамдулам, М.Нарантуяа, Х.Хулан, Х.Батзориг, Д.Энхтайван, Р.Бямба, Н.Баярбаатар, Д.Содномпүрэв, Д.Пүрэв, нябо Дулмаа, санхүүч Ганчимэг, референт Д.Эрдэнэсанаа, Ц.Дамдинсүрэн, н.Дашдулам, С.Галя, Н.Чимгээ, бичээч М.Хартолгой, С.Оюунгэрэл, Самбалхүндэв, А.Бунзаа, доктор Ж.Бор, Р.Отгон, Х.Олзвой нарын олон арван нэрийг хүрээлэн байгуулагдсаны 40 жилийн ойн өндөрлөгөөс эргэн дурсахад таатай байна.

Сүүлийн жилүүдэд ОУСХ-ийн судалгааны чиглэл, цар хүрээ өргөжин шинэчлэгдсэнээр хөрш хоёр орон БНХАУ, ОХУ болон Япон, Солонгос, АНУ, Герман, Төв Ази, Энэтхэг зэрэг орон, бүс нутгийг дагнан судлах орон судлалын ажил идэвхжсэн билээ.